

Монгол Улс дахь шашны аялал жуулчлал, хөгжүүлэх боломж

Борбандийн Мөнхцацралт *

Докторант

*Шинжлэх Ухааны Академийн Философийн
хүрээлэн*

*Улаанбаатар, Монгол Улс
munkhsatsralt@mas.ac.mn*

Шараагийн Догмийчойдон

Магистр

*Шинжлэх Ухааны Академийн Олон улс
судлалын хүрээлэн*

*Улаанбаатар, Монгол Улс
dogmii@mas.ac.mn*

Хураангуй

Аялал жуулчлал, шашин судлалын салбарт хавсарга асуудал мэт хоцорч байгаа сэдэв бол шашны аялал жуулчлал билээ. Бид энэхүү өгүүлэлдээ манай улсад шашны аялал жуулчлалыг судлаачид хэрхэн авч үзэж байгааг тоймлохыг зорилгоо. Мөн цаашид шашны аялал жуулчлалыг бие даасан салбар болгон хөгжүүлэх нөөц боломжийг зарим орны туршлага жишээнд үндэслэн хөгжүүлж болох тухай, тэрчлэн бидэнд бурхны шашнаар дамжин өвлөж ирсэн арвин түүх, соёл, археологийн олдвор, сүм хийд хийгээд байгалийн үзэсгэлэнтэй хосолмол байдлаар орших сүм хийд, сүм хийдийн туурь, музей, уран зураг, уран баримал, цутгамал, наамал, хөөмөл байгааг шашны аялал жуулчлалын бүтээгдэхүүн, тодорхой зорилготой маршрут болгож ашиглах боломжийн тухай өгүүлэв.

Мөн бурхны шашны сүм хийд орон тэргүүтэй бүхий л эд зүйл нь угтаа бэлгэдэл, ёс, утга агуулгатай байдгийг шашны аялал жуулчлалын хүрээнд домогчлон, түүхчлэн тайлбарласнаар аялагч, жуулчдын сонирхлыг татах боломжтой юм. Энэ онд Х Богд Жавзандамба тодорсон, Монголын Бурхан Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба лам солигдсон зэрэг түүхэн үйл явдлууд тохиолдсонтой холбоотойгоор цаашид монголын уламжлалт бурхны шашин нь бурхны шашинтны төв, шашны аялал жуулчлал, эргэл мөргөлийн төв болон хөгжих боломжийн тухай өөрсдийн саналаа дэвшүүлэхийг хичээв.

Түлхүүр үгс: *аялал жуулчлал, шашны аялал жуулчлал, бурхны шашин
буддын шашин*

* The Corresponding author

<https://orcid.org/0000-0001-5462-2356>
<https://orcid.org/0000-0003-1330-4591>



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

Received: 30 August 2023
Accepted: 15 October 2023

Religious tourism in Mongolia and opportunities for its development

Munkhtsatsralt Borbandi*

*Ph.D candidate student
Institute of Philosophy, Mongolian Academy of
Sciences
Ulaanbaatar, Mongolia
munkhtsatsralt@mas.ac.mn*

Dogmiichoidon Sharaa

*MA
Institute of International Studies, Mongolian
Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia
dogmii@mas.ac.mn*

Abstract:

Religious tourism is a growing branch of tourism and religious studies. In this study, we have considered how researchers have studied religious tourism in our country. In the future, religious tourism can be developed based on the experience of other countries about the resources and opportunities for independent development, as well as the rich history, culture, archaeological finds, temples and natural beauty that have been passed down to us through the religion of God, temples, ruins of temples, museums, and it was told about the possibility of observing the presence of pictures, sculptures, castings, appliques, and objects as a means of religious tourism and a route with a specific purpose.

It is also possible to attract the interest of travelers and tourists by explaining that all things, including temples and shrines, have their symbols, customs and meanings in the context of religious tourism. This year, due to historical events such as the appointment of X Bogda Jawzandamba and the change of abbot of Gandantekechenlin Monastery, the Mongolian God Religious Center, we tried to put forward our suggestions on the possibility of developing the Mongolian Traditional Religion of Gods as a center for god worshipers, religious tourism and pilgrimage.

Keywords: tourism, religious tourism, Buddhism

I. Оршил

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-д газар зүй, байгаль, түүх соёлын онцлогт тулгуурлан зургаан бүсэд ангилан, 2050 он хүртэл аялал жуулчлалыг 3 үе шаттайгаар хөгжүүлэхээр тусгасан билээ. Уг 3 үе шатны эхний хэсэг 2021-2030 он хүртэл хэрэгжих “Бүтээн байгуулалтын үе” эхлээд байна. Гэвч дэлхий дахиныг хамарсан цар тахлын үр нөлөөгөөр улс орнууд хилээ хааж, хориг тавьснаар эдийн засаг, нийгэм, соёл хүмүүнлэгийн орчин, нөхцөл байдал өөрчлөгдсөн. Эдүгээ цар тахлын дэлгэрэлт намжиж, улс орнууд хилээ нээж, хэвийн байдалдаа эргэн орж, эдийн засгаа сэргээхээр дор бүрнээ чармайн ажиллаж байна. Дэлхийд тархсан цар тахлын ид үед аялал жуулчлалын салбар хамгийн зогсонги байдалд байсан ч цар тахлын дараа аялал жуулчлалын салбар “тэсрэх” магадлалтай (Д.Отгонбаяр 2023) гэсэн салбарынхны өөдрөг төсөөлөл хүлээлт байсан. Монгол Улсын ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ч цар тахлын дараа хамгийн хурдтай сэргэх салбар бол дэлхийд аялал жуулчлалын салбар гэдгийг ч онцолж “Саалиа бэлдэхээр саваа бэлд гэдэгчлэн Монголд ирэх гадаад жуулчдад үүсдэг бэрхшээл, хүнд суртал, хариуцлагагүй байдлыг арилгаж, цахим элчин сайдын яам байгуулах, цахим виз олгох, агаарын тээврийг либералчлах асуудлыг цаг алдалгүй

шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна” (Л.Оюун-Эрдэнэ 2021, 14)^{2*} хэмээн УИХ-ын чуулганд мэдэгдэж байв.

Энэ дагуу цар тахлын үед аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаанд тулгарсан бэрхшээл сорилт, үүнийг хэрхэн даван туулах, анхаарах асуудал, төр засгаас үзүүлэх дэмжлэг боломжийн талаар хурал симпозиум зохион байгуулагдаж, аялал жуулчлалын салбарыг сэргээх тухай хэлэлцэх болов. Мөн “Аялал жуулчлалын салбарыг сэргээх стратеги төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийг байгуулж 2022-2023 онд жуулчдын тоон өсөлтийг эрчимтэй нэмэгдүүлэн 2019 оны хэмжээнд хүргэх, улмаар 2024 онд гадаадын нэг сая жуулчин хүлээн авах, аялал жуулчлалын салбараас олох орлогын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлэхээр төлөвлөн, хэлэлцэж санал санаачилга гаргах болсон (Аялал жуулчлалыг сэргээх стратеги төлөвлөгөө 2021).

Цар тахлын өмнө буюу 2019 онд Монгол Улс аялал жуулчлалын салбар хөгжиж буй 60^{3*} гаруй жилийнхээ хугацаанд хамгийн олон буюу 577,000 жуулчныг хүлээн авчээ. 2018 онд гадаадын нийт 529,360 жуулчин ирсэн бол 2019 онд 577,300 болж манай улсыг зорин ирэх жуулчдын тоо 9 хувиар нэмэгдэж, 2019 онд аялал жуулчлалын салбараас олсон орлого өмнөх оноос 10,2 хувиар өссөн дүнтэй гарсан байна. Ерөнхийдөө БНХАУ, ОХУ, БНСУ-аас ирсэн жуулчид тоогоор тэргүүлдэг (НЗДХА, Аялал жуулчлалын газар 2020). Гэвч ирсэн жуулчдыг аялал жуулчлалын төрөл зүйлээр нь ангилсан судалгаа тоо баримт байдаггүй, тийм статистик тоо гаргахад ч төвөгтэй.

Орчин үед дэлхий дахины аялал жуулчлал эрчимтэй хөгжиж, олон улсын аялал жуулчлалын нөөц улам баяжиж, цоо шинэ, сонин содон зүйлээр төрөлжиж байна. Урд нь аялал жуулчлалыг байгалийн, соёлын хүрээнд ойлгож байсан бол өнөө үед аялал жуулчлалын төрөл агуулга, чиг хандлага улам баяжин өргөжиж, шашны жуулчлал (religious tourism), экстрим жуулчлал (extreme tourism),^{4**} адал явдалт жуулчлал (adventure travel),^{5***} эко жуулчлал (eco-tourism), бүр эрүүл мэндийн жуулчлал^{6****} гэсэн төрлүүд нэмэгдсээр байна. Ийнхүү аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэхэд тухайн орны улс төрийн байдал, эдийн засгийн хүчин чадал, гадаад эдийн засгийн үйл ажиллагаа, нийгэм - хүн ам, соёл үйлчилгээ зэрэг олон хүчин зүйл нөлөөлж иржээ.

2021 онд эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай “Шинэ

сэргэлтийн бодлого” (Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын

² * Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилсонтой холбогдуулан УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн хэлсэн үг.

³ * 1954 онд Гадаад Худалдааны Яамны дэргэд “Гадаадын жуулчдад үйлчлэх товчоо” байгуулагдаж анчин, жуулчид болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудын групп жуулчдад үйлчлэх болсноор Монгол оронд аялал жуулчлал хөгжих эх үүсвэр тавигдсан гэж үздэг.

⁴ ** аюултай газар (уул, ширэнгэн ой, цөл, агуй, хавцал гэх мэт) аялах эсвэл аюултай аялалд оролцох зэрэг аялал жуулчлал юм. <https://www.thetravel.com/extreme-tourism-dangerous-places-world/>

⁵ *** тусгай ур чадвар, бие бялдрын хүч чармайлт шаарддаг тодорхой хэмжээний эрсдэлтэй (бодит эсвэл ойлгогдох) эрэл хайгуул, аяллыг хамарсан нэг төрлийн аялал жуулчлал юм.

⁶ **** Сүүлийн үед монголд яригдах болсон эрүүл мэндийн жуулчлалыг интернэтээр хайж үзэхээр medical tourism, health tourism гэсэн төрлүүд байна. Цааш нь нягталж үзсэнгүй.

1 дүгээр хавсралт. 2021) УИХ-аар батлагдаж, түүнд аялал жуулчлалын салбарыг дэмжин ажиллахаар тусгасан байгаа. Ийм учир аялал жуулчлалын салбарыг эрчимжүүлэхэд ихээхэн дэм болохуйц ач холбогдолтой аялал жуулчлалын нэгэн төрөл, бүтээгдэхүүн нь шашны аялал жуулчлал байж болох юм. Үүнийг хөгжүүлэх нөөц бололцоо манай улсад байгаа бөгөөд хөрш улсуудын угсаа гарвал нэгт монгол угсаатнуудыг Монголд жуулчлуулах, ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх нэгэн гарц нь шашны аялал жуулчлал байж улмаар Монгол туургатны шашин шүтлэгийн төв болж хөгжих боломжийн тухай мөн шашны аялал жуулчлалыг буддын шашинтай холбон хөгжүүлэх боломжийн тухай судлаачдын саналыг тоймлохыг эрмэлзлээ.

II. Судалгааны арга зүй

Дэлхий нийтийг хамран тархсан КОВИД-19 цар тахлын улмаас хүндрэл бэрхшээл, сорилттой тулгарсан салбар бол аялал жуулчлалын салбар гэдгийг дээр өгүүлсэн. Цар тахлын дараахь аялал жуулчлалын салбарын сэргэлт, төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого чиглэл, манай улсад сүүлийн жилүүдэд хийгдсэн шашны чиглэлээрх судалгаа, хөтөлбөр, шашны зүтгэлтнүүдийн айлчлал, тэдгээрийн тод жишээ болох Ромын пап Францисийн төрийн айлчлал, түүний дараахь хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээн дэх мэдээлэл, ярилцлага зэрэгт анализ хийж, аялал жуулчлалын чиглэлээрх гаргасан сүүлийн үеийн эрдэм шинжилгээний зарим бүтээлүүдийн дэвшүүлсэн дүгнэлт зөвлөмжүүдэд агуулгын шинжилгээ, харьцуулалт хийх арга, арга зүйг үндэслэн Монгол Улсад зонхилох буддын шашны сүм хийд, түүх дурсгалын үнэт өв соёлоор дамжуулан шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг авч үзлээ.

III. Хэлэлцүүлэг

Судлаачдын бичсэнээс үзэхэд (Ж.Алтайбаатар,Р.Бадрал 2012) 1991 оноос “Шашны аялал жуулчлал” гэх нэр томъёог дэлхийд албан ёсоор хэрэглэх болсон байна. Шашны зорилгоор шашны ариун газрууд болон шашны төвүүдээр жилээс илүүгүй хугацаагаар зорчиж буй жуулчныг шашны жуулчин, эдгээр газруудад зохион байгуулагдаж буй аялал жуулчлалын үйлчилгээг “Шашны аялал жуулчлал” (Ж.Алтайбаатар,Р.Бадрал 2012) хэмээн үздэг аж. а) Мөргөлийн, б) шашны зорилготой аялал жуулчлал гэсэн үндсэн хоёр хэлбэрээр шашны аялал жуулчлал хөгжиж байгааг (Ж.Алтайбаатар,Р.Бадрал 2012) мөн дурдсан байна. Үүнд,

а) *Шашны мөргөлийн аялал жуулчлалд:*

- Мөргөл
- Шашин дэлгэрүүлэх
- Бясалгалын
- Шашны кампууд^{7*}
- Сайн дурын

б) *Шашны зорилготой аялал жуулчлалд:*

- Хурал чуулганд оролцох

⁷ * АНУ-ын христийн шашны 120 мянга орчим сүм хийдүүд Христийн камп хэмээх арга хэмжээнд хамрагддаг бөгөөд 4 сүм бүрд нэг камп ногдог. Энэ арга хэмжээний хүрээнд христийн шашны залуу сүсэгтнүүдийг хүмүүжүүлэх, сургаал номлолоо заах үйл ажиллагааг тус кампууд зохион байгуулдаг.

- Танин мэдэхүйн
- Адал явдал, идэвхтэй амралт
- Оюутан, залуучуудын
- Гэр бүлийн гэх мэт хэлбэрүүдийг багтаан ойлгодог аж.

Энэ утгаар Монголын дотоодын аялал жуулчлалыг харахад шашны жуулчлал огт байхгүй гэж хэлж болохгүй юм. Дотооддоо монголчууд уламжлалт баяр цагаан сараар л томоохон хийдүүд, Хамрын хийд энергийн Түвэд очиж, шашны баяр ёслол, шашны үйл ажиллагаанд холоос зорин очиж оролцдог. Гэвч энэ нь аялал жуулчлалын салбарын орлогод бараг нөлөөгүй. Байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан урин дулаан цаг, зуны улиралд аялал жуулчлалын улирал эхэлж, шашны хэргээр зорчих нь их боловч яг шашны аялал жуулчлал гэж салгаж хэлэхэд хэцүү, байгалийн аялал жуулчлалын хавсарга болсон өнгө аястай байна. Тэгвэл сонгодог утгаар нь шашны аялал жуулчлалын хэлбэрийг агуулсан жуулчлал нь гадагшаа буюу гадаад улсын шашны төв рүү Монголоос зорчдог чиглэлтэй байгаа. Үүнд: урд хөршийн Утай, Гүмбэн, Лхас; хойд хөршийн Иволгын дацан, Энэтхэгийн Дармасалад аялж, сүсэгтэн олон мөргөл үйлдэж байна. Энэ талын (гадагшаа чиглэсэн) шашны аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг цөөнгүй компаниуд ч бий болжээ.

Гадагшаа чиглэсэн шашны аялал жуулчлалын урсгалыг дотооддоо шингээх, гаднаас жуулчдыг татах мөн шашны аялал жуулчлалын бүтээгдэхүүн буюу брэнд гаргах талаар судлаачид (МонЦаМэ тойм №5 2013) хөндөн бичих болж цөөнгүй санал дэвшүүлсэн өгүүлэл нийтлэл хэвлэгдсэн. Бас зарим орон нутагт шашны аялал жуулчлалын газар байгуулах санаачилга гарч байсны нэгээр 2018 онд Архангай аймгийн Булган сумын Баянбэрх хайрхны өвөрт Хүслийн хадны хажууд 5 метр гаруй өндөртэй хүүхдийн Бүжинлхам бурхныг бүтээж, шашны аялал жуулчлалын цогцолбор маягаар байгуулахаар болсон тухай мэдээлж (МонЦаМэ 2023) байсныг нэрлэж болно. Мөн онд тухайн үеийн БОАЖ-ын сайд Н.Цэрэнбат Монголын бурхны шашны хийдүүдийн тэргүүнийг хүлээн авч уулзаж, шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар хамтарч ажиллахыг санал болгож (Шашны аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтран ажиллахыг хүсэв. 2021) байв. 2019 онд тус яамнаас “Шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер хүртэл зарласан (Шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх судалгаа хийж, төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер. 2022) байдаг. Шашны аялал жуулчлалтай холбогдуулан Монголын Бурхан шашинтны төв “Тандантэгчинлэн хийд орчмыг соёл, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх” Засгийн газрын тогтоол 2021 оны 6-р сард гарч байсан. Гэвч тэнд хийгдэх бүтээн байгуулалт Богд Зонховын хөшөө цогцолборын ажлыг эхэлсэн боловч эдийн засгийн хямралтай нөхцөл байдлын улмаас цахим орчин, олон нийтийн зарим хэсгийн шүүмжлэлд багагүй өртөж, төсвийн хөрөнгөөр бүтээн байгуулалтыг хийхгүй, олон нийтийн хандив тусламжаар барих болсноо төслийг эхлүүлсэн компани мэдэгдэж, энэхүү бүтээн байгуулалтын ажил зогсонги байдалд орсон (Хуурамч компанийн нэрээр “Богд Зонхова”-г үргэлжлүүлж байна уу? 2022).

Монгол орны түүх, соёл өв уламжлалд нь буддын шашин гүнзгий шингэн

уусаж, уламжлагдан ирсэн бөгөөд Монголын буддизм гэсэн өвөрмөц онцлогийг тодорхойлж болохуйц түүхэн замналыг туулж, хөгжиж өнөөг хүрснийг эрдэмтэн судлаачид тэмдэглэсээр ирсэн. Жишээлбэл, академич Г.Лувсанцэрэн судалгаандаа Бурханы шашныг нийтэд хүргэхэд түүний онолын гүнзгий үндэслэлийг ухааран тайлах, цаг үе, орон нөхцөлд зохицсон хэлбэрийг олоход(Г.Лувсанцэрэн., Э.Ариунаа 2007, 32) Монголын анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэжээ.

Шинжлэх ухааны доктор Д.Гантөмөр “Аялахуйн философи” нэгэн сэдэвт бүтээлдээ аялах, аялал жуулчлал, аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг олон хэл, сурвалжид тулгуурлан тайлбарласан байна. Тус бүтээлдээ “хүн төрөлтний түүхэнд газар зүй аян, худалдаа наймаа, ан гөрөө, мөргөлийн сэдлээр хийсэн орон зайн шилжилтийг аялал жуулчлалын үүсэл гэж үздэг” (Д.Гантөмөр 2021, 21) хэмээн тэмдэглээд, аялал жуулчлалын олон төрөл хэлбэрээс эргэл мөргөлийн аяллын тухай дараахь хэдэн зүйлийг тэмдэглэжээ. Эргэл мөргөл хийх, бадарчлах, (pilgrimage, паломничество), монгол хэлний толь бичигт “Аялал жуулчлал гэдэг нь тодорхой хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар оршин сууж буй газраасаа өөр газарт хийх аялал” гэж тайлбарлан тэмдэглэжээ. Эргэл мөргөл хийх, бадарчлах, зэрэг нь аялал жуулчлалын эх байгаад зогсохгүй шашны аялал жуулчлал эртнээс үүдэлтэйг ч эндээс харж болохоор байна. Доктор Д.Гантөмөр аялал, жуулчлалыг философи арга зүйн үүднээс тодорхойлж, дэлхийн судлаачдын аялал жуулчлалыг хэрхэн тодорхойлж үзсэнийг тоймложээ. Тэрбээр судалгаандаа Монголчуудын хувьд аяллын талаарх ойлголт нь ан гөрөө хийх, аян, худалдаа наймаа, жин бараа тээх, амьдралын хэрэгцээ, нүүдэллэхүйн онцлог, хүн байгалийн шүтэлцээнд оршдог (Д.Гантөмөр 2021, 63) гэдгийг онцлоод мөн бадарчин, аянчин, жинчин хэмээх нь нэгэн зүйл аялал хийж буй лам, хар хүмүүсийг хэлж байгаа боловч ертөнцийг танин мэдэж яваа хүн хэмээн тэмдэглэжээ. Зохиогч дээрх үзлээ буддын сэтгэл төдийтний философийн арга зүйн үүднээс судлан, олон жишээ баримтаар баталгаажуулсан бүтээлч дүгнэлт санааг дэвшүүлсэн байна. Монголын бурхан шашны түүхэнд эргэл мөргөл хийх, даяан бясалгал хийхээр зорьсон газрынхаа сонин баримт мэдээг тэмдэглэж, бүтээл туурвиж байсан жишээг ч мөн онцолжээ. Тухайлбал, Ноён хутагт Данзанравжаа Утайд залраад буцахдаа “Саруул тунгалаг” зохиолоо айлдсаныг эх зохиолоос нь авч эшилжээ. Мөн “Сэрүүн тунгалаг уулын зохионгуйгаас” дэлхийн олон иргэд мөс залгиж, цас идэж амиа тэвчихээс умартан асар их сүрэг гарган тасран үгүй ирэх юуны учир хэмээвээс эмийн хаан Манзуширын нэрийг сонсгосон, дүрийг үзсэнээр ард иргэд зуун мянган галавт муу заяанд унах үгүй болой гэж номножээ (Д.Гантөмөр 2021, 154). Эндээс аялал жуулчлал хийх анхны зорилго, хүсэл тэмүүлэлд хүний итгэл бишрэл, сүсэг ихээхэн хамааралтай болохыг тодруулж харж болж байна. Энэ тухай доктор Д.Гантөмөр аялал жуулчлал бол хүний итгэл бишрэл ба эргэлзээнээс үүдэлтэйг ч тодорхойлж хэлжээ. Мөн тэр бээр Монголчуудын түүхэнд эргэл мөргөл, аянчин бадарчин хийж ирсэн шашны аяллын арвин баримт байгааг онцлон тэмдэглэжээ.

Мөн шинжлэх ухааны доктор Д.Гантөмөр тус нэгэн сэдэвт бүтээлийнхээ дүгнэлт хэсэгт аялал жуулчлалын түгээмэл шинжийг тайлбарлахад, буддын мэдлэг ухааны суурь онол-мэдлэгийн үүднээс зовлонг ертөнцөөс гэтлэх арга замтай гэдэг үндэслэлд, мөн бүхнийг сэтгэлийн чанартай гэж үзээд буддын йогачара философийн үүднээс аялал хийх сэдэл шалтгаан, аяллын объект хийгээд субъектийн харилцаа болон аялагчийн сэтгэлд үүсэх үзэл “Би”-д барьсан үзлийг тайлбарлах, дижитал нийгмийн цахим мэдээллийн дэмээр аялах газрын тухай төсөөлөл үүсгэж, улмаар оюун сэтгэлийн үйлээр виртуал хэлбэрээр аялах, үүнийг бясалгахуйн үйлтэй харьцуулах боломжтой гэсэн дэвшилтэт шинэлэг дүгнэлтүүдийг хийжээ. Эдгээр дүгнэлтүүдээс ямар ч гэсэн манай улсад буддын шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх цаад онол-үндэслэл нь байна, орон газар, аялал жуулчлалын түүх дурсгалт гол объектууд нь ч байна гэдгийг батлан харж болохоор байна.

Нөгөө талаас, манай улсад аялж, жуулчлаад тэмдэглэлээ үлдээсэн Плано Карпини, А.М.Позднеев тэргүүтэй аялагч, судлагчдын бүтээл манай орны судалгаанд чухал хэрэглэхүүн болдог. Тухайлбал: Энэ онд А.М.Позднеевын “Монгол дахь буддын сүм хийд, лам хуврагуудын аж байдал, лам нар ард иргэдийн харилцааны тухай” бүтээл орчуулагдан хэвлэгджээ. Ташрамд хэлэхэд, А.Позднеевын энэхүү бүтээлийн нэгдүгээр бүлгийг академич Г.Лувсанцэрэн, дөрөвдүгээр бүлгийг шинжлэх ухааны доктор М.Гантуяа нар орчуулж ном сэтгүүлд хэсэгчлэн хэвлэсэн байдаг (Лам нарын сэтгүүл 2010). Уг бүтээл нь Монголын буддын сүм хийдийн тухай ерөнхий тэмдэглэл, Монголын буддын сүм хийд ба эдлэл хэрэглэл, Шашинтнууд ба лам хуврагууд, Хувилгаад, Хурал ном гэсэн таван бүлгээс бүтнэ. Тус зохиолд тухайн цаг үеийн Монголчуудын сүсэг бишрэл ямар байсан талаар тэр нь нийгмийн амьдрал, сүм хийдийн харилцаанд хэрхэн илэрч байгааг нягт өгүүлэхийн зэрэгцээ өнөө бидний мартаж санаж, орхиж гэсэн олон зан заншил, зан үйл, бэлгэдэл, шинж байдал, тоон үзүүлэлт, баримт, нэр томъёог тэмдэглэжээ. Тухайлбал, Буддын сургаалаар сүм хийдийн гадна дотор засалд мөрдвөл олон шаардлага байдаг бөгөөд гол тахил нь сүм хийдийн дүүрэн залдаг бурхны сэрэг дүрүүд юм (А.М.Позднеев 2023, 63). Эдгээр бурхан тахил, шүтээнээ сүсэгтнүүд Шагжамуни бурхан адил дээдэлдэг. Буддын сургаал ёсоор бол чин сүсэгтэй хэн боловч багш шүтээнээ бурхантай адилтган үзэж, итгэж, хүндэлж, мөргөх, оюун сэтгэлээрээ түүнд тэмүүлж залбирал мөргөлөө өргөх ёстойг тэмдэглэсэн байна. Сүсэгтэн ард хэдэн арав, хэдэн зуун удаа сүм гороолохоос гадна гэрийн үүднээсээ хийд хүртэл, Долнуураас Утай уул хүртэл, цаашлаад Төвөдийн хилээс Лхас хүртэл ийнхүү мөргөл хийж очсон цахар лам таних тухайгаа ч тэмдэглэжээ. Энэ жишээ мөн л эргэл мөргөл, итгэл бишрэл нь хүний аялахуйн сэдэл болж буйг бататгана. Тус бүтээл нь Монголын нүүдлийн соёл иргэншилтэй, бурхны шашин үзэл санаа нэвт сүлэлдэж ирснийг тод өгүүлжээ. Монголд бурхны шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөл, үзэсгэлэнт байгаль, хүрээ хийд хосолсон жуулчлалын объект ч, түүнээ түүх домгоор баяжуулан утгажуулж тайлбарлах цаад онолын эх үндэс нь байгааг эл жишээнээс харж болж байна.

Сүүлийн гурван жилийн статистик тоо баримтаар Буддын шашны сүм хийдийн тоо буурсан үзүүлэлт харагдаж байна.

	Шашин	2020	2021	2022
Улсын дүн	Будда	150	121	117

Гэсэн хэдий ч Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчинлэн хийд, Зүүн хүрээ Дашчойлин хийд, Эрдэнэ зуу хийд, Амарбаясгалант хийд, Манзуширын хийд, Хамрын хийд, Аглаг бүтээлийн хийд, Чойжин ламын сүм музей, Богд хааны ордон музей зэрэг манай улсын томоохон хийдүүд, Хүрээ цам даншиг наадам, Гонгор бумбын тахилга, Майдар эргэх зэрэг шашны ёслол, олон арван эртний сүм хийдүүдийн туурь балгас, байгалийн үзэсгэлэнтэй газруудтай хослон оршдог нь Монголд шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц боломж бийг харуулж байна. Хэдхэн жилийн өмнө олдсон Архангай аймгийн Цахир сумын Содномдаржаа уулын оройд байх Өвгөн гэсэр лам Цэвээнрашийн Чүлтэмжамц, аграмба Равсалын Санжайжав нарын занданшуулсан шарил нь Буриадын Иволгын дацангийн Итгэлт хамбын занданшуулсан шарилтай адил ч, занданшуулсан арга технологи, хадгалагдан ирсэн байдал нь огт өөр тул шинжлэх ухааны үүднээс тайлбарлаж чадаагүй байна. Буриадын Иволгын дацан Итгэлт хамбын занданшуулсан шарилыг шашны аялал жуулчлалын бүтээгдэхүүн брэнд болгон алдаршуулж, жуулчдыг татаж чадсан жишээ туршлагаас судлаад Монголд одоогоор олдсон уг хоёр ч “Итгэлт хамба”-ыг шашны аялал жуулчлалын шүтээн болгон нутагшуулах боломж байгаа билээ.

Шашны аялал жуулчлал ч гэлтгүй аялал жуулчлалын салбарт бүтээгдэхүүн буюу брэнд гаргахад домог, бүр төгсгөөгүй домог чухал үүрэгтэйг судлаачид бичиж ярьсан байна. Цаашид домог зүй судлал нь аялал жуулчлалын салбарт чухал нөлөөтэй. Энэ талаар домгийг ашиглан хамгийн оновчтой зөв менежмент хийсэн гэж “Женко тур бюро” ХК-ийн бүтээн байгуулсан Цонжин болдог цогцолбор, тэнд “Чингис хаан ташуураа гэж орхисон...” гэх домгийг үндэслэжээ. Мөн түүх домгийг үндэслэсэн аялал жуулчлалын газар бол Өвөр монголын Ордост “Чингис хааны онгон” хэмээх аялал жуулчлалын цогцолбор, бүтээн байгуулалт үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Чингис хааны сүнсэн онгоныг тахиж, тайлга хийдэг бөгөөд жилд 30 гаруй төрлийн 2000 орчим тахилгыг хийдгээс жил бүрийн билгийн тооллын 3-р сарын 21-ний өдөр болдог хаврын улирлын цагаан сүргийн их тайлга хамгийн алдартай. Аялал жуулчлалын төв болсон энэ газар 2006 онд ЮНЕСКО-д биет бус соёлын өв хэмээн бүртгүүлсэн бөгөөд, БНХАУ-ын 5А зэрэглэлийн жуулчны газар болон хөгжсөн байна (Sonin.mn 2022).

Харин одоо энэ бүгдээс манай улсад шашны аялал жуулчлалын бүс, маршрут ямар байх вэ? шашны аялал жуулчлалын гол онцлог нь юу байх вэ? гэсэн асуулт гарч ирж байна. 1991 онд МУИС-д Буддын судлал, Шашин судлалын тэнхим байгуулагдсан үеэс тэнхимийн нэг гол хэрэгжүүлж ирсэн хөтөлбөр бол “Хээрийн дадлага”-ийн хөтөлбөр юм. Энэ “Хээрийн дадлагын” хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн маршрут чиглэлээр дадлагад явдаг бөгөөд энд зөвхөн нэг маршрутын талаар товч авч үзье. Улаанбаатараас Хөгнө тарнын хийд, Өвгөн хийд (Булган аймаг Рашаант сум), Хөгнө тарнын хийдээс Эрдэнэзуу хийд (Өвөрхангай аймаг Хархорин сум), Эрдэнэзуу хийдээс Шанхийн хийд, Баруун хүрээ (Өвөрхангай аймаг Хархорин сум Шанх баг), Баруун хүрээндээс Илдэн бэйлийн хүрээ, Гандан-норовлин хийд,

Гандан-Норовлин хийдээс Төвхөн хийд (Бат-Өлзий сум), Төвхөн хийдээс Хотонт сумын хийд (Архангай аймаг Хотонт сум), Хотонтын хийдээс Дэчинпунцаглин хийд (Архангай аймаг) Дэчинпунцаглин хийдээс Тарвачинболин хийд (Архангай аймаг Батцэнгэл сум Тарвачинболин хийдээс Заяын хүрээ (Архангай Цэцэрлэг хот), Заяын хүрээнээс Өөлд бэйсийн хүрээ, Алтан зуу хийд (Архангай аймаг Өлзийт сум), Өөлд бэйсийн хүрээнээс Хөшөө цайдам (Архангай аймаг Хашаат сум) гэсэн маршрутаар буцаад Эрдэнэ зуу, Хөгнө хан дайран Улаанбаатар хүртэл 1500 км орчим аялал хийдэг. Энэ дадлагын хүрээнд сүм, хүрээ хийдийн түүхэн хөгжил, бүс нутгийн түүх, сүм дуганы бүтэц зохион байгуулалт, гол сахиус шүтээн, түүнд холбогдох шашны зан үйл, өнөөгийн хурал ном, уншлагын үйл ажиллагаа, сүм дуганы сэргээлт, хадгалалт хамгаалалт зэрэг судалгааны олон сэдвээр судалгаа хийж, тэмдэглэл хөтлөн, тайлан хамгаалдаг. Нэг талаас цаашид шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагаанд дээрх маршрутын жишээгээр өөр бусад олон маршрут чиглэлийг гаргаж хөгжүүлэх бололцоотойг, нөгөө талаас МУИС-д дээрх байдлаар бэлтгэгдсэн мэргэжлийн шашин судлаачдыг дан шашны аялал жуулчлал гэлтгүй аялал жуулчлалын салбарт ажиллуулах, хүний нөөцөө бүрдүүлэх боломжтойг өгүүлэх гэсэн юм.

Хэдийгээр түүхэндээ 700 гаруй сүм хийдээ устган, лам нараа хэлмэгдүүлсэн түүх бий ч уламжлалт буддын шашныхаа уг үндсийг таслалгүй, хадгалан ирж, сэргээн хөгжүүлж, энэ чиглэлээрх судалгаа ч эрчимтэй хийгдсээр байна. 2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газраас эрхэлсэн томоохон судалгааны дүнд нийслэл хот, 21 аймаг 365 сумын нутаг дэвсгэрт байсан хуучин болон шинээр сэргээгдсэн нийт 1050 сүм хийдийн тухай мэдээг товчоолон (С.Цэдэндамба 2009, хii, x) гаргасан байдаг. Сүүлийн жилүүдэд ШУА-ийн Археологийн хүрээлэн нь Монголын эртний соёлын уг мөн чанарыг нээх, биет өв хэрэглэгдэхүүнд агуулагдаж буй бэлгэдэл зүйн болоод агуулгын далд хэлбэрүүдийг тайлбарлан таниулах, судалгаа шинжилгээг шинэ шатанд гаргахаар зорьж (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2022, 11) ажиллаж байгаагийнхаа хүрээнд Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх Эрдэм соёлын хүрээлэнтэй хамтран “Өв соёлын Голомт” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд “Буддын шашин ба археологи” гэсэн цуврал эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулжээ. Монголын бурхны шашин дэлгэрсэн түүхэн замналын гурван үеийн бурхны шашинд холбогдох археологийн олдвор, тэдгээрт хийсэн судалгааны үр дүнгүүдийг нэгтгэсэн эмхэтгэл хэвлүүлжээ. Мөн сүүл үеийн Завхан аймгийн Алдархаан сумын Ямаан ус, Булган аймгийн Сэлэнгэ сумын нутаг Ингэт толгойн дурсгал, Түргэний голын балгасын судалгаа зэрэг томоохон малтлага судалгаанд бурхны шашны холбогдолт археологийн олдвор, эд өлгийн зүйлд лабораторийн судалгаа хийсний дараа археологийн эрдэмтэд судлаачид, геофизикийн судлаачид, сүм хийдийн архитектур судлаач, шашин судлаачдын хамтын үр дүнгийн хэлэлцүүлгээр нэгдсэн үр дүнг танилцуулах нь чухал болохыг судлаачид онцлон тэмдэглэжээ (GoGo.mn 2022).

Цаашид эдгээр судалгааны дүнд олдсон бурхны шашны ховор нандин олдворууд, манай орны түүхэнд холбогдох томоохон сүм хийдийн туурь балгас зэргийг судалж, сэргээж, аялал жуулчлалын салбартай холбогдуулан манай улсын улсын түүх, шинжлэх ухаан танин мэдэхүүд холбогдох музей болгон хөгжүүлэх

боломжийг бүрдүүлж ажиллах нь чухал юм.

Манай улсаас Итгэл хамба, Утай, Далай лам зэрэгт мөргөл үйлдэхээр ОХУ-ын БН Буриад Улс, Хятад, Энэтхэг улс руу аялагчдын тоо багагүйг дээр өгүүлсэн. Тэгвэл эсрэгээрээ манай оронд шашны нэрт зүтгэлтнүүд, төлөөлөгчид ирэхэд нэгдсэн томоохон уулзалт чуулган зохион байгуулагддагаас гадна тэдгээр хүмүүстэй *хувийн харилцааны үүднээс ч уулзах* тохиолдол элбэг байдаг.



Тухайлбал, Шри Шри Рави Шанкар (Eguur.mn 2021) нь Монголд нийт 4 удаа айлчилсан бөгөөд энэ айлчлалынхаа хүрээнд манай улсын төв талбай, Буянт-Ухаа цогцолборт Чакра Крияа хамтын бясалгалыг үйлдсэн. Сонирхолтой нь энэ үйл ажиллагаанд Рави Шанкарын уламжлал “Амьдрах урлаг” бясалгалын төвийн гишүүдээс гадна итгэгч, дагагч, бясалгагч биш хүмүүс ч өргөнөөр оролцсон явдал юм. Энэ нь манай улсын хүн ам оюун санааны амар амгаланг

эрэлхийлэгч, хайгч байхын зэрэгцээ гэгээрсэн, нэр хүндтэй шашны зүтгэлтнүүдэд мөргөх, адис авах эрэлт ихтэй байдгийг харж болохоор байна.



2023 оны 9 дүгээр сард Гэгээн ширээт улсын тэргүүн пап Францис манай улсад төрийн айлчлал хийсэн билээ. Пап Францис (Montsame.mn 2023) айлчлалын үеэр олон нийтэд хандаж хэлэхдээ *“Талын нүүдэлчин амьдралд төрж, өргөн уудам газар нутагт тархан сууж, хөрш зэргэлдээх олон соёлоос ялгарах өвөрмөц онцлогтой байна гэдэг бол монгол гэрийн соёлоос суралцах зүйл их гэсэн үг юм”*

(President.mn 2023) хэмээн нүүдлийн соёл иргэншил, байгаль экологид ээлтэй монгол гэр сууц, өвөрмөц онцлогийг бахдан өгүүлсэн билээ. Мөн тэрбээр Монголчуудын итгэл үнэмшил сүсэг бишрэлийн талаар *“Оюун санаа, сүсэг бишрэлийн торгон мэдрэмж танай соёлын мөн чанарын эд эс бүхэнд гүн гүнзгий оршдог учраас Монгол Улс шашин шүтлэгийн эрх чөлөөний бэлгэ тэмдэг байх нь аргагүй юм”* (President.mn 2023) хэмээн өгүүлсэн хэдий ч Монголчуудын өнөд дээдэлж ирсэн мөнх хөх тэнгэрийг хүндэлж буйгаа илэрхийлээд *“Аливаа шашин шүтлэг дотоодын хагарал бутралгүй, өөрийн оюун санааны язгуур уламжлалаа хадгалж байсан цагт эрүүл, хөгжингүй нийгмийг бүтээн байгуулахад итгээж болох дэмжлэг”* (President.mn 2023) гэдгийг онцлон өгүүлсэн билээ. Ромын пап Францисийн айлдсан үг бүхэлдээ манай улсын уламжлалт соёл, шашин шүтлэгт хүндэтгэл илэрхийлсэн утга санааг илэрхийлжээ. Ромын пап Францисийн энэхүү айлчлалын үеэр манай улсад гадаадын 3500 гаруй католик шашны итгэгчид, зочид хүрэлцэн иржээ. Энэ мөн л дээрх жишээ баримтад өгүүлсэн хүмүүсийн итгэл

үнэмшил, сүсэг бишрэл нь аялах, мөргөлийн аяллын анхны сэдэл болж буйг бататгана.

Дээрх жишээнээс үзэхэд гадаад орны зорих шашны аялал жуулчлал байдгаас гадна шашны нэрт зүтгэлтнүүдэд мөргөх, залбирах, хамт бясалгах, шашны идэвхтэй үйл ажиллагаанд оролцох (энх тайвны гүйлт, зургийн үзэсгэлэн, хүмүүнлэгийн үйл ажиллагаа г.м) зорчих хөдөлгөөн, аялал их байдгийг харж болохоор байна. Мөн манай оронд шинэ тутамд дэлгэрэн үйл ажиллагаагаа явуулж байгаа шашны байгууллагууд нь гадаадад байх төв байгууллагын сүсэгтнүүдтэйгээ харилцан мөргөл, залбирал хийх, төв шүтээн байгууллагадаа очиж залбирах, үндэслэгч тэргүүнтэйгээ уулзаж адис хүртэх, бясалгах, харилцан туршлага солилцох журмаар тус орноор аялах, давхар сургаал номлолоо сурталчлах үзэгдэл тохиолдол ч цөөнгүй. Үүнийг ч бас шашны аялал жуулчлалын бүрдэл хэсэг болгон нарийвчлан үзэх шаардлагатай юм.

1990-ээд оноос хойш бараг 4 жил тутам Дээрхийн гэгээн Далай лам манай улсад айлчилсан бөгөөд гадаад дотоодын сүсэгтэн олон энэхүү айлчлалд чухал ач холбогдол өгдөг юм. 2016 онд XIV Далай лам айлчлалын үед хийсэн хэвлэлийн бага хурал дээр X Богд Жавзандамба хутагт Монгол Улсад мэндэлсэн болохыг олон нийтэд зарлаж байсан. Тэгвэл энэ онд Богд Жавзандамбын X дүрийн хувилгаан тодорсныг олон нийтэд зарласан. Мөн энэ оны 10-р сард Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчинлэн хийдийн тэргүүн, Хамба номун хан, гавж Д.Чойжамц хамбын ламын үүрэгт ажлаас чөлөөлж, Тэргүүн их хамбаар лхаарамба Д.Жавзандоржийг томилсон зэрэг нь Монголын бурхны шашны түүхэнд тодоор тэмдэглэгдэх үйл явдлууд болж өрнөсөн. Үүнтэй холбоотой монголын бурхны шашинд гарах өөрчлөлт, шинэчлэл, менежментийн үйл ажиллагаанаас шашны аялал жуулчлал, ялангуяа сүсэгтэн олны эргэл мөргөлийн төвөөс гадна сэтгэл, оюун санааны төв болох нь ихээхэн хамааралтай болж байгааг тэмдэглүүштэй.

IV. Дүгнэлт

Монгол Улсын зонхилох шашин нь буддын шашин бөгөөд хүн амын 56.6%, сүсэгтнүүдийн 70.3% нь уламжлалт бурхны шашин шүтдэг. Буддын шашны сүм хийдүүд нь нийт улсын хэмжээнд буюу хот, хөдөө орон нутагт байдаг. Буддын шашны эд өлгий зүйлс их; утга соёлын зүйл, буддын гүн ухааны ном судар бүтээл, шашин соёлын бүтээгдэхүүн элбэг; хутагт хувилгаад олон төрсөн, монгол, төвөдийн уламжлалт анагаах ухаан харьцангуй хөгжсөн зэрэг олон бодит хүчин зүйлд үндэслэн манай оронд шашны аялал жуулчлалаар гадаад дотоодын сүсэгтнүүд, жуулчдыг татах, аялагчдын эрэлтийг нэмэгдүүлэх боломжтой гэж бид үзэж байна.

Шашны төдийгүй түүхэнд томоохон байр эзэлсэн IX Богд Жавзандамбын хойд дүр тодорсон, Монголын Бурхны Шашинтны Төв Гандантэгчинлин хийдийн тэргүүн хамба лам солигдож шинэ залуу шашны боловсон хүчнүүд төрөн гарч буй зэрэг нь шашны шинэчлэлийг эхлүүлж буй үйл явдал гэж харж болохоор байна. Иймээс шашны сургаал, айлдвар, өргөн хүрээтэй томоохон хурал чуулган, даншиг наадам, фестиваль, үзэсгэлэн зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан шашны аялал жуулчлагчдын тоог нэмэгдүүлж болох юм.

2023 оны зуны улиралд манай улсыг зорьж ирсэн аялагчид, контент

бүтээгчдийн видео контент, танилцуулга дэлхий нийтэд хандалт ихтэй байгаа нь ч манай улсыг сонирхогч, жуулчлагчдын тоо улам бүр нэмэгдэх төлөвтэйг харуулж байна. Гэхдээ шашны аялал жуулчлалыг шууд бие даан хөгжүүлэх нь эхэндээ хүндрэлтэй байж болох тул аялал жуулчлалын бусад төрөлтэй хавсруулах нь зохистой.

Цаашдаа шашны аялал жуулчлалыг хавсарга асуудал мэтээр биш, харин аялал жуулчлал, шашин судлалын салбар дундын томоохон чиглэл болгож хөгжүүлэх боломж манай оронд байгаа юм. Ийнхүү манай улсад шашны аялал жуулчлалыг бие даан хөгжүүлэх нөөц нь бурхны шашны сүм хийд, түүх, онол, шашны эд хэрэглэгдэхүүн мөн бөгөөд эдгээр нь гадаад дотоодын сүсэгтнүүд, аялагч, жуулчлагчдын сонирхлыг татах нь дамжиггүй.

Ашигласан материал

Отгонбаяр Д. 2023. “Аялал жуулчлалын салбар “тэг” зогссон ч цар тахлын дараа “тэсрэх” магадлалтай. 10 08. <https://www.montsame.mn/mn/read/258783>.

Оюун-Эрдэнэ Л. 2021. *Азийн хүлэг улс – Алсын хараа 2050. 3-р дэвтэр*, УБ. Nepko publishing .

2021. “Аялал жуулчлалыг сэргээх стратеги төлөвлөгөө.” 12 08. <https://www.montsame.mn/mn/read/283485>.

НЗДХА, Аялал жуулчлалын газар. 2020. 01 20. <https://tourism.ub.gov.mn/?p=8972>.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. 2021. “Шинэ сэргэлтийн бодлого.”<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082551211&showType=1>.

Алтайбаатар Ж., Бадрал Р. 2012. “Шашны аялал жуулчлал. <https://religionmongolia.wordpress.com/>. 11 05. <https://religionmongolia.wordpress.com/2012/11/05/%d1%88%d0%b0%d1%88%d0%bd%d1%8b-%d0%b0%d1%8f%d0%bb%d0%b0%d0%bb-%d0%b6%d1%83%d1%83%d0%bb%d1%87%d0%bb%d0%b0%d0%bb/>.

МонЦаМэ тойм №5. 2013. 05.

МонЦаМэ. “Шашны аялал жуулчлалын цогцолборын эхлэл болгож Бүжинлхам бурхны шавыг тавив. “ <https://www.montsame.mn/mn/read/84745>

Шашны аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтран ажиллахыг хүсэв. <http://www.olloo.mn/n/50548.html> .

Шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх судалгаа хийж, төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер. <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1555659077965>.

“Хуурамч компанийн нэрээр “Богд Зонхова”-г үргэлжлүүлж байна уу?.” <https://news.mn/r/2530534/> .

Лувсанцэрэн Г., Ариунаа Э. 2007. *Буддын уламжлалт мэдлэг ухааны үндэс*. УБ.

Гантөмөр Д. 2021. *Аялахуйн философи*. УБ.

2010. “Лам нарын сэтгүүл .”

Позднеев А.М. 2023. *Монгол дахь буддын сүм хийд, лам хуврагуудын аж байдал, лам нар*,

ард иргэдийн харилцааны тухай тэмдэглэл. Уб.

Sonin.mn <https://sonin.mn/news/enews/93092> .

Цэдэндамба С. 2009. ред, *Монголын сүм хийдийн түүхэн товчоон. Уб.*

2022. “Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.” “*Буддын шаашин ба археологи*” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 11 дэх тал

2022. “GoGo.mn.” https://gogo.mn/r/n2mwm?fbclid=IwAR1gKzczKRVZ3ynRIFAUr0yiK2c_vEaW5JXt22Nq1L6b5ItmDQwqYBT6AUy.

2021. *Eguur.mn*. <https://eguur.mn/30318/>.

2023. *Montsame.mn* . <https://montsame.mn/mnread/325820>.

2023. *President.mn*. 09 02. <https://president.mn/27213>